



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/182

Улаанбаатар хот

Газар эзэмших эрх дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх дуусгавар болгох хүсэлт ирүүлсэн хавсралтад заагдсан 7 (долоо) иргэний газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрх дуусгавар болж байгаа иргэдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариу мэдэгдэж хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/136 дугаар захирамжийн О.Өнөболд, А.Оюунчимэг, А.Балжмаа, А.Оюунтуяа, Л.Пүрэвсүрэн, Н.Цэнд-Аюуш, Ц.Хандармаа нарт хамаарах хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД